



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А178

Хажуу шинэ-Ус

Ажил хүлээн авах комисс томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралт Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 4.10.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны 07 дугаар сарын 16-ний өдөр “Смарт контрол” ХХК-тай байгуулсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Дэнжийн гудамжнуудыг өнгөт, гэрэлтүүлэгтэй болгох” ажилд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийг хүлээн авах эрх бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Даваасүрэн	(Засаг даргын орлогч)
Гишүүд:	Н.Ганбат	(Санхүү албаны дарга)
	Л.Батбаатар	(4 дүгээр багийн Засаг дарга)
	У.Сүнжидмаа	(Засаг даргын Тамгын газрын нярав)
	Г.Бадралтөгөлдөр	(ШҮЦН)

2.“Смарт контрол” ХХК хийж гүйцэтгэсэн “Дэнжийн гудамжнуудыг өнгөт, гэрэлтүүлэгтэй болгох” ажлыг хүлээн авах ажлын гэрээний хавсралт болон техникийн тодорхойлолтыг үндэслэн нэр төрөл, хэмжих нэгж, тоо ширхэг, хүчин чадал бүрээр нь акт үйлдэн хүлээн авч үндсэн хөрөнгөнд бүртгэн авч ажиллахыг Санхүү албаны дарга (Н.Ганбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482401078